

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/304/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/148
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1,8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын 9 жилийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын 9 жилийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 13 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 91,3 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,735,176.46	132,075,003.75
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	26,842,663.93	79,780,994.92
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,842,663.93	79,780,994.92
9	Төгрөг	26,842,663.93	79,780,994.92
10	Төрийн сангийн харилцах	26,842,663.93	79,780,994.92
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
27	АВЛАГА	5,158,024.37	5,097,955.44
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	5,158,024.37	5,097,955.44
60	БАРАА МАТЕРИАЛ	54,734,488.16	47,196,053.39
66	Хангамжийн материал	52,768,488.16	44,900,053.39
68	Аж ахуйн материал	39,031,628.56	32,730,810.88
70	Түлш шатах тослох материал	391,544.00	-
72	Хүнсний материал	4,866,141.93	3,378,241.94
73	Бусад хангамжийн материал	8,479,173.67	8,791,000.57
75	Мал, амьтад	1,966,000.00	2,296,000.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	498,462,145.73	488,861,551.02
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	498,462,145.73	488,861,551.02
108	Биет хөрөнгө	449,768,479.09	440,259,551.02
109	Барилга, байгууламж	510,542,853.35	510,542,853.35
110	Хуримтлагдсан элэгдэл	(134,084,777.65)	(167,450,723.05)
113	Машин, тоног төхөөрөмж	101,631,692.55	120,413,398.30
114	Хуримтлагдсан элэгдэл	(65,320,839.82)	(60,316,214.11)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,498,540.28	82,340,645.48
116	Хуримтлагдсан элэгдэл	(60,446,017.41)	(62,217,436.74)
117	Зам гүүрийн барилга байгууламж	2,891,000.00	2,891,000.00
118	Хуримтлагдсан элэгдэл	(2,891,000.00)	(2,891,000.00)
122	Бусад үндсэн хөрөнгө	772,000.00	380,000.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(772,000.00)	(380,000.00)
125	Номын фонд	16,947,027.79	16,947,027.79
126	Биет бус хөрөнгө	48,693,666.64	48,602,000.00
127	Програм хангамж	2,194,360.00	1,832,510.00
128	Хасагдуулга	(2,102,693.36)	(1,832,510.00)
129	Бусад биет бус хөрөнгө	48,602,000.00	48,602,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	585,197,322.19	620,936,554.77
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	585,197,322.19	620,936,554.77
215	Засгийн газрын хувь оролцоо	585,197,322.19	620,936,554.77
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутги	229,056,929.12	229,056,929.12
217	Өмч: -Төрийн өмч	229,056,929.12	229,056,929.12
223	Хуримтлагдсан үр дүн	(224,190,889.41)	(188,431,352.24)
224	Өмнөх үеийн үр дүн	(224,190,889.41)	(224,170,584.82)
225	Тайлант үеийн үр дүн	-	35,739,232.58
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	580,331,282.48	580,310,977.89
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	585,197,322.19	620,936,554.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,755,811.82	812,597,074.90
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,929,811.82	28,125,726.90
77	Нийтлэг татварын бус орлого	29,929,811.82	28,125,726.90
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	27,822,259.00	26,488,000.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	824,400.00	-
87	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	26,997,859.00	26,488,000.00
89	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	2,107,552.82	656,826.90
92	Бусад орлого	-	980,900.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,027,200.00	118,833,800.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	530,798,800.00	665,637,548.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,564,200.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсөв	15,564,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,463,000.00	118,833,800.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөв	145,463,000.00	118,833,800.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	703,782,335.91	776,857,842.32
148	УРСГАЛ ЗАРДАЛ	703,782,335.91	776,857,842.32
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,142,624.61	752,598,381.19
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	386,491,885.40	452,951,269.82
151	Цалин	330,280,204.40	353,619,357.22
152	Нэмэгдэл цалин	44,056,222.00	81,477,581.05
154	Урамшуулал	5,120,369.00	17,854,331.55
155	Гэрээтийн цалин	7,035,090.00	-
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,098,647.35	58,001,857.68
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,214,706.93	40,487,758.98
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,564,755.90	4,545,644.59
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,176,965.54	3,650,155.08
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,353,691.86	790,173.21
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,788,527.12	8,528,125.82
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,388,098.00	117,507,838.87
165	Гэрэл цахилгааны зардал	4,259,498.00	5,854,459.87
166	Түлш, халаалтын зардал	97,093,600.00	111,653,379.00
167	Цэвэр, бохир усны зардал	35,000.00	-
170	Хангамж, бараа материалын зардал	734,100.00	7,095,167.68
172	Тээвэр, шатахууны зардал	396,500.00	-
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	337,600.00	600,050.00
178	Бараа материал актасны зардал	-	6,495,117.68
181	Нормативт зардал	33,423,288.80	44,877,999.99
183	Хоол	33,423,288.80	44,877,999.99
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
189	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хура	1,242,600.00	3,476,960.44
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	719,400.00	929,400.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	523,200.00	2,547,560.44
209	Бараа үйлчилгээний бусад зардал	66,764,005.06	67,687,286.71
210	Бараа үйлчилгээний бусад зардал	13,299,976.00	12,276,092.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	4,896,280.00	4,725,600.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,567,749.06	50,685,594.71
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,639,711.30	24,259,461.13
228	Бусад урсгал шилжүүлэг	38,388,695.98	24,033,500.00
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,824,495.98	19,938,000.00
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаа	15,564,200.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	4,095,500.00
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох та	20,251,015.32	225,961.13
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,251,015.32	225,961.13
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	17,973,475.92	35,739,232.58
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	17,973,475.92	35,739,232.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	692,650,400.00	785,452,248.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	824,400.00	980,900.00
78	Нийтлэг татварын бус орлого	824,400.00	980,900.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	824,400.00	-
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	824,400.00	-
92	Бусад орлого	-	980,900.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	691,826,000.00	784,471,348.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	530,798,800.00	665,637,548.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,564,200.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	15,564,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,463,000.00	118,833,800.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,463,000.00	118,833,800.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	658,345,736.07	717,916,917.01
148	УРСГАЛ ЗАРДАЛ	658,345,736.07	717,916,917.01
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,786,800.75	693,751,155.88
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	391,299,018.40	452,798,992.86
151	Үндсэн цалин	292,045,004.38	328,949,064.49
152	Нэмэгдэл	84,538,150.02	108,387,068.98
154	Үр дүнгийн урамшуулал	14,715,864.00	15,462,859.39
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	49,431,514.35	58,094,065.71
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,811,359.30	40,359,619.57
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,024,881.83	4,563,403.85
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,221,885.38	3,650,763.12
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	759,426.22	861,148.53
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,613,961.62	8,659,130.64
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	101,388,098.00	117,607,838.87
165	Гэрэл цахилгааны зардал	4,259,498.00	5,854,459.87
166	Түлш, халаалтын зардал	97,093,600.00	111,653,379.00
167	Цэвэр, бохир усны зардал	35,000.00	100,000.00
181	Нормативт зардал	35,058,320.00	43,383,800.00
183	Хоол, хүнс	35,058,320.00	43,383,800.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
189	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,030,050.00	4,077,010.44
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	719,400.00	929,400.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,310,650.00	3,147,610.44
208	Бараа үйлчилгээний бусад зардал	17,579,800.00	16,789,448.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	12,219,300.00	12,063,848.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	5,360,500.00	4,725,600.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,558,935.32	24,165,761.13
225	Бусад урсгал шилжүүлэг	39,307,920.00	23,939,800.00
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	23,743,720.00	19,844,300.00
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,564,200.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	4,095,500.00
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,251,015.32	225,961.13
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,251,015.32	225,961.13
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,304,663.93	67,535,330.99
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,462,000.00	14,597,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,462,000.00	14,597,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	7,462,000.00	14,597,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,462,000.00	14,597,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-	(7,462,000.00)	(14,597,000.00)
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	26,842,663.93	52,938,330.99
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	26,842,663.93
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,842,663.93	79,780,994.92

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	152,219,288.46	657,168,923.14
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	152,219,288.46	657,168,923.14
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-31567460.84	31,567,460.84
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	(224,190,889.40)	585,197,322.19
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	(224,190,889.40)	585,197,322.20
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	20,304.59	20,304.59
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	(224,190,889.40)	585,217,626.78
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		20,304.59	0	(20,304.59)
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		0	35,739,232.58	35,739,232.58
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	229,056,929.12	580,331,282.50	(188,431,352.24)	620,936,554.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	26,842,663.93	(26,842,663.93)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	801,645,350.00	732,287,955.88	69,357,394.12	91.35
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	801,645,350.00	732,287,955.88	69,357,394.12	91.35
4	Бараа, үйлчилгээний зардал	771,803,450.00	708,348,155.88	63,455,294.12	91.78
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,457,000.00	452,798,992.86	54,658,007.14	89.23
6	Үндсэн цалин	341,271,400.00	328,949,064.49	12,322,335.51	96.39
7	Нэмэгдэл	147,364,300.00	108,387,068.98	38,977,231.02	73.55
9	Урамшуулал	18,821,300.00	15,462,859.39	3,358,440.61	82.16
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,637,250.00	58,094,065.71	5,543,184.29	91.29
12	Тэтгэврийн даатгал	43,274,300.00	40,359,619.57	2,914,680.43	93.26
13	Тэтгэмжийн даатгал	5,091,100.00	4,563,403.85	527,696.15	89.63
14	ҮОМШӨ ний даатгал	4,071,450.00	3,650,763.12	420,686.88	89.67
15	Ажилгүйдлийн даатгал	1,018,300.00	861,148.53	157,151.47	84.57
16	Эрүүл мэндийн даатгал	10,182,100.00	8,659,130.64	1,522,969.36	85.04
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,800,700.00	117,607,838.87	1,192,861.13	99.00
18	Гэрэл цахилгаан	7,122,300.00	5,854,459.87	1,267,840.13	82.20
19	Түлш, халаалт	111,478,400.00	111,653,379.00	(174,979.00)	100.16
20	Цэвэр, бохир ус	200,000.00	100,000.00	100,000.00	50.00
30	Нормативт зардал	43,998,200.00	43,383,800.00	614,400.00	98.60
32	Хоол, хүнс	43,998,200.00	43,383,800.00	614,400.00	98.60
34	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
38	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,131,300.00	4,077,010.44	54,289.56	98.69
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	980,900.00	929,400.00	51,500.00	94.75
49	Мэдээллийн технологийн зардал	3,150,400.00	3,147,610.44	2,789.56	99.91
53	Бараа үйлчилгээний бусад зардал	32,779,000.00	31,386,448.00	1,392,552.00	95.75
54	Бараа үйлчилгээний бусад зардал	28,053,400.00	26,660,848.00	1,392,552.00	95.04
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,725,600.00	4,725,600.00	-	100.00

66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,841,900.00	23,939,800.00	5,902,100.00	80.22
70	Бусад урсгал шилжүүлэг	29,841,900.00	23,939,800.00	5,902,100.00	80.22
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	25,746,400.00	19,844,300.00	5,902,100.00	77.08
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	4,095,500.00	4,095,500.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	787,619,400.00	784,471,348.00	3,148,052.00	99.60
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	668,492,700.00	665,637,548.00	2,855,152.00	99.57
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	668,492,700.00	665,637,548.00	2,855,152.00	99.57
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,126,700.00	118,833,800.00	292,900.00	99.75
104	Орон нутгийн төсвөөс	119,126,700.00	118,833,800.00	292,900.00	99.75
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	26,842,663.93	(26,842,663.93)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	79,780,994.92	(79,780,994.92)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль хамтын оролцоо үнэлгээний үр дүнг үндэслэн сургуулийн менежментийг сайжруулж хэрэглэгдэхүүнд суурилан сургалтын чанарт ахиц гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 89,0 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь 29 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн

хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 89,0 хувьтай үнэлэгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 1 өдөр Сумын хяналт шалгалт үнэлгээний хорооны шалгалтаар 86,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,600.6 мянган төгрөгөөр буюу 1,93% хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,842.6	79,780.9	52,938.3
Авлага	5,158.0	5,097.9	-60.1
Урьдчилгаа			
Бараа материал	54,734.4	47,196.9	-7,538.4

Үндсэн хөрөнгө	498,462.1	488,861.5	-9,600.6
Нийт хөрөнгө	585,197.3	620,936.5	35,739.2
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	229,056.9	229,056.9	
Хуримтлагдсан үр дүн	-224,190.8	-188,431.3	-35,759.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	580,331.2	580,310.9	20.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	585,197.3	620,936.5	35,739.2

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 52,938.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь /орон тоо хэмнэж ажилласан/ үндсэн цалин, нэмэгдэл зэргийг хэмнэнэснээс мөн урд оны зарцуулаагүй үлдэгдлээс 26,842.6 мянган төгрөг шилжиж орж ирсэн зэргээс мөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 60.1 мянган төгрөг байгаа нь цалингийн нэгдсэн системийн программд алдаа гарч шимтгэл татварыг суутгуулсан байна

Бараа материал дансны үлдэгдэл 7,538.4 мянган төгрөгөөр буурсан нь тогтмол худалдан авдаг бараа материалын үнэ өссөн, мөн аж ахуйн материал данснаас 6,495.1 мянган төгрөгийн бараа актласан зэргээс шалтгаажээ.

Үндсэн хөрөнгө данс 9,600.6 мянган төгрөгөөр буурсан нь: машин тоног төхөөрөмж 15,913.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 4,547.8 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 392.0 мянган төгрөг, программ хангамж 361.8 мянган төгрөг нийт 21,215.0 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна.

Хандиваар БШУГазраас багш бүр компьютер хөтөлбөрөөр 9,288.0 мянган төгрөгийн 9 ширхэг зөөврийн компьютер, хувь иргэн нутгийн зөвлөлөөс 17,200.0 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна. Улсын төсвийн хөрөнгөөр 14,597.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж 13,607.0 мянган төгрөг, тавилаг эд хогшил 990.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна. Сумын ИТХ-н 2023 оны 6-р сарын 11 ний өдрийн 27 тоо тогтоолоор тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө, программ хангамж зэрэг нийт 21,215.0 мянган төгрөгийн хөрөнгө, аж ахуйн материал 6,495.0 мянган төгрөгийн бараа материал тус тус актласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 681,844.6 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 119,800.7 мянган төгрөг нийт зарлагыг 801,645.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 801,645.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 681,844.6 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 732,287.9 мянган төгрөг буюу 91,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 69,357.3 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 54,658.0 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 5,543.1 мянган төгрөг,

байр ашиглалтын зардлаас 1,192.8 мянган төгрөг, хоол хүнснээс 6,516.0 мянган төгрөг бусад зардлаас 1,392.5 мянган төгрөг, төлбөр хураамж 54.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,260.2	1,260.2		100%	
2	80312-Сургалт семинар	945.1	630.1	315.0	66,7%	
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,260.2	1,260.2		100%	
4	81801-Үдийн цай хөтөлбөр	25,746.4	19,844.3	5,902.1	77,1%	
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	71,866.6	68,926.3	9,940.3	87,4%	
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	13,171.2	13,171.1		100%	
7	81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,835.3	2,835.3		100%	
8	81827- Бичиг үсгийн боловсрол олгох	2,953.7	2,476.6	47.1	83,8%	
9	81834- Болосролын стандарт	458,327.1	404,231.7	54,095.3	88,2%	
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	94,237.7	94,237.7		100%	
11	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.6	150.6		100%	
12	81848- Сурах бичгийн түрээс	980.9	929.4	51.5	94,7%	
13	80111 Төрийн өмчийн барилгын ашиглалтын тогтмол зардал	119,800.7	118,607.8	1,192.8	99%	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

							/мянган төгрөгөөр/	
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан		
1	71802-80226	2023-12-31	-Байр ашиглалтын	100%	1,260.2	1,260.2		

			үйлчилгээ			
2	71802-80312	2023-12-31	-Сургалт семинар	66,7%	9,45.1	630.1
3	71802-81605	2023-12-31	-Эрүүл мэндийг дэмжих	100%	1,260.2	1,260.2
4	71802-81801	2023-12-31	-Үдийн цай хөтөлбөр	77,1%	25,746.4	19,844.3
5	71802-81806	2023-12-31	- Дотуур байрны үйлчилгээ	87,4%	71,866.6	68,926.3
6	71802-81816	2023-12-31	- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	13,171.2	13,171.2
7	71802-81823	2023-12-31	- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	100%	2,835.3	2,835.3
8	71802-81827	2023-12-31	- Бичиг үсгийн боловсрол олгох	83,8%	2,953.7	2,476.6
9	71802-81834	2023-12-31	- Боловсролын стандарт	88,2%	458,327.1	404,231.7
10	71802-81835	2023-12-31	-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	100%	94,237.7	94,237.7
11	71802-81844	2023-12-31	- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	100%	150.6	150.6
12	71802-81848	2023-12-31	- Сурах бичгийн түрээс	94,7%	980.9	929.4
13	71802-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын ашиглалтын тогтмол зардал	99%	119,800.7	118,607.8

Бичиг үсгийн боловсрол олгох арга хэмжээ нь хангалтгүй болсон нь сургалтанд хамрах ирц муугаас нөлөөлсөн. Сурах бичгийн түрээс арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурах бичиг түрээслэх сурагчид бага байсан нь нөлөөлсөн. Дотуур байрны үйлчилгээ, үдийн цай хөтөлбөр дутуу хэрэгжсэн нь ирц хангалтгүй байгаагаас шалтгаалсан.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс ферсон танхимын тохижилтонд зориулж 14 ш таблет худалдан авалт хийсэн байна. Бусад худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог, нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 645,000.0 мянган төгрөгнөөс 2.0 хувиар буюу 12,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,300.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 13 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 54,658.0 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 5,543.1 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,392.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 155 мэдээллийг байршуулж 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн/ гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 100 хувь

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Акт				
Албан шаардлага					
Зөвлөмж	5	493,857.0	5	493,857.0	100%
Нийт дүн	5	493,857.0	5	493,857.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс 110.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 110.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 02 өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 3-р хавсралт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын /4.2.3.6-д эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан/ гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардал гаргасан	1	110.0	1	110.0								
Дүн	1	110.0		110.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 155 мэдээлэлийг хугацаанд нь мэдээлж, 4 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn